

## ХӨСҮТ-ИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ

2018.06.08

№	Илэрсэн зөрчил дутагдал	Төлөвлөсөн ажил	Хугацаа	Биелэлт
<b>Нэг. Үндсэн хөрөнгө</b>				
1.	<p>ДЭМБ-ын санхүүжилтээр 2017 онд 93,165.2 мянган төгрөгийн үнэ бүхий МКФ-074 маркийн хөргөгч 20, МК304 маркийн хөргөгч 20 ширхэгийг тус тус хүлээн авахдаа бараа материалын дансанд тусгасан, урд онд хүлээн авсан МК304 маркийн 7 ширхэг хөргөгчийг үндсэн хөрөнгөнд тусгажээ.</p> <p>2017 онд эдгээр хөрөнгүүдийг эрүүл мэндийн байгууллагуудад шилжүүлэхдээ урд онд 2,176.0 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон, ижил төрлийн хөрөнгүүдийг 2 өөр хөрөнгийн /Үндсэн хөрөнгө, Бараа материалын/ дансдад бүртгэсэн байна.</p>	<p>Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгийг хүлээн авахдаа хөрөнгүүдийг ангиллын дагуу бүртгэж, дахин хуваарилагдах хөрөнгүүдийг аж ахуйн материалын дансаар дамжуулан санхүүжүүлэгч байгууллагатай тооцоо нийлж, баталгаажуулан данс бүртгэлд тусгаж байх.</p>	2018 оны II улирал	<p>Урьд 2016 оны өмнө НББ-ийн хуучин стандартаар орон нутагт шилжүүлэх хөрөнгийг үндсэн хөрөнгөнд бүртгэж элэгдэл тооцдог байсаныг 2017 оноос бараа материал дансанд бүртгэж байна.</p> <p>Глобаль сантай 2017 онд нийлүүлэгдсэн хандив тусламжаар төслийн хүрээнд ирсэн хөрөнгөнд тооллого хийж, данс бүртгэлд тусгасан байдлыг шалгаж, тооцоо нийлэв.</p>
2.	<p>Глобаль сангийн хөрөнгийн санхүүжилтээр ирж буй зарим хөрөнгүүдийг анхан шатны бүрдэл дутуу баримтаар бүртгэлд авсан байна.</p>			

	<p>Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүрээнд хөрөнгүүдийг хуваарилах явцад гарах алдаа зөрчлийг арилгах үүднээс санхүүжүүлэгч байгууллагатай тооцоо нийлж, баталгаажуулах данс бүртгэлд үнэн зөв тусгах ажлуудыг нэгдсэн удирдлагаар хангах, эрүүл мэндийн бусад байгууллагуудад хөрөнгө хуваарилах явцад хяналт тавих шаардлагатай байна.</p> <p>Энэ нь санхүүжүүлэгч байгууллагатай тооцоо нийлж, баталгаажуулаагүйгээс төсөл, арга хэмжээний хүрээнд хөрөнгүүдийг хүлээн авах, хуваарилах явцад хөрөнгө дутагдах, данс бүртгэлд тусгагдахгүй үлдэх эрсдэлтэй байна.</p>			<p>ЭМСайдын тушаалтай тулгаж баталгаажуулав.</p>
<b>Хоёр. Мөнгөн хөрөнгө</b>				
3.	<p>Мөнгөн кассын өдөр тутмын гүйлгээнд хөтлөгддөг анхан шатны баримт болох кассын орлогын ордерыг урьдчилан дугаарлан мөнгөн кассын няравт хүлээлгэж өгөөгүй байгаа нь үйл ажиллагааны орлого дутуу тусгагдах эрсдлийг үүсгэж байна.</p> <p>Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.</p>	<p>Мөнгөн кассын өдөр тутмын үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах үүднээс эмнэлгийн үйлчилгээг хэрэглэгчдэд түргэн шуурхай хүргэх, цахим бүртгэлийн програм хангамжийг нэвтрүүлэх асуудлыг зохих шатны байгууллагуудад уламжилж шийдвэрлүүлэх.</p>	2018 оны IV улирал	<p>Кассын орлогын ордерыг урьдчилан дугаарлаж хэвшсэн. Төвийн амбулатори, зарим лабораториуд E-health программд холбогдож эхлээд байгаа. IV улиралдаа багтаад кассыг холбох шат дараалсан ажлууд хийгдэж дуусна.</p>